Mongol - Тайвшруулах Судрууд - Comfort Scriptures

2 Коринт 1:2-4 Бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс нигүүлсэл болон амар тайван нь та нарт байх болтугай. 3 Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэр бол өршөөлийн Эцэг, мөн бүх тайвшралын Бурхан мөн. 4 Бурхан биднийг тайвшруулсан тэрхүү тайвшралаар бид аливаа зовлонд орогсдыг тайвшруулах чадвартай байхын тулд Тэр биднийг бүх зовлон дотор маань тайвшруулдаг юм.

Сургаалт Үгс 15:13 Зүрх жаргалтай бол нүүр царай хөгжилтэй. Харин зүрх гутрах үед сүнс эмтрэнэ.

Хаадын дээд 8:66 Найм дахь өдөрт Соломон ард түмнийг буцаан явуулахад, тэд хааныг ерөөв. ЭЗЭН Өөрийн боол Давид болон Өөрийн ард түмэн Израильд үзүүлсэн бүхий л сайн сайханд баярласан сэтгэлтэй, жаргалтайгаар хүмүүс тус тусын майхнууд уруу харьцгаалаа.

Шастирын дээд 16:10 Түүний ариун нэрд аддар байг. ЭЗЭНийг хайж буй хүний зүрх баяр баясгалантай байх болтутай.

Сургаалт Үгс 12:25 Зүрхэн дэх шаналал хүнийг дарамталдаг бол Эелдэг үг түүнийг баярлуулдаг.

Сургаалт Үгс 13:12 Хүлээгдсэн итгэл найдвар зүрхийг өвчлүүлдэг бол Биелсэн хүсэл амийн мод болой.

Исаиа 30:26 ЭЗЭН Өөрийн ард түмний бэртэнгийг боож, яр шархыг нь эмчлэх өдөрт сарны гэрэл нь нарны гэрэл шиг болж, нарны гэрэл нь долоон өдрийн гэрэл мэт долоо дахин хурц болох ажээ.

Хосеа 13:8 Бамбаруушнуудаа булаалгасан баавгай шиг Би тэдэнтэй тулгарч, тэдний цээжийг нь яран тастах болно. Зэрлэг араатан тэднийг тастчихтай адил тэнд Би бас эм арслан мэт тэднийг залгина.

1 Самуел 1:8,10 Тэгэхэд түүний нөхөр Елкана түүнд — Ханна, чи юунд уйлж, яагаад хоол, унд ч идэхгүй байна вэ? Юунд зүрх сэтгэл нь уйтгарлана вэ? Би чамд арван хөвгүүнээс дээргүй юү? гэв. 10 Ихэд шаналсан Ханна ЭЗЭНд залбиран, гашуунаар уйлж байв.

Дуулал 25:16,17 Би ганцаардсан болон зовж шаналсан учир Над уруу эргэж, намайг нигүүлсээч. 17 Зүрхний минь зовлонгууд ихэссэн юм. Зүдгүүрээс минь намайг гаргаач.

Дуулал 34:18 ЭЗЭН эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг бөгөөд Сүнсээрээ гэмшигчдийг авардаг.

Дуулал 38:8 Намайг сульдуулан доройтуулж, маш хүндээр бэртээжээ. Зүрхний минь шаналлаас болж би ёолдог.

Дуулал 55:4 Миний дотор зүрх минь шимширч, Үхлийн аюулууд ч намайг нөмөрсөн.

Дуулал 61:2,3 Миний зүрх сэтгэл дарамтанд ороход газар дэлхийн хязгаараас би Таныг дууддаг. 3 Учир нь Та миний хоргодох газар, Дайсны эсрэг бат бэх цамхаг байсаар ирсэн билээ.
Дуулал 62:8 Хүмүүс ээ, хэзээд Түүнд итгэ. Түүний өмнө зүрхээ нээ. Бурхан бидэнд хоргодох газар юм. Села
Дуулал 73:26 Махан бие ба зүрх минь үгүй болж болно, Харин Бурхан бол мөнхөд зүрхний минь хүч болон миний хувь юм.
Дуулал 77:2,3 Зовлон зүдгүүрийнхээ өдөр би Эзэнийг хайсан. Шөнөөр ч гар минь ядрахгүйгээр сунгагдсан байдаг. Сэтгэл минь ч тайвшрахаас татгалздаг. 3 Би Бурханыг санаад, зовж шаналсан байдаг. Би санаа алдаад, сүнс минь сульддаг. Села
Дуулал 86:11 Өө, ЭЗЭН, Өөрийн замыг надад зааж өгөөч. Би Таны үнэнээр явах болно. Таны нэрээс эмээхээр зүрхийг нэгтгээч.
Дуулал 109:22 Учир нь би бол зүдрэгч ба гачигдагч бөгөөд Зүрх минь миний дотор шархадсан.
Дуулал 112:7,8 Тэрээр муу мэдээнээс айхгүй. ЭЗЭНд итгэн түүний зүрх бат юм. 8 Түүний зүрх гуйвшгүй. Тэрээр өстнүүд уруугаа бах нь ханан харах хүртэл айхгуй.
Дуулал 143:4 Тиймээс сүнс минь миний дотор сульдсан билээ. Зүрх минь ч миний дотор зогсох шахсан юм.
Дуулал 147:3 Тэр эмтэрсэн зүрхтэй хүмүүсийг анагааж, Тэдний шархыг боодог.
Сургаалт Үгс 14:30 Амар тайван зүрх бие махбодод амийг өгдөг бол Хүсэл тачаал ясан дахь идээ бээр юм.
Номлогчийн Үгс 1:13 Тэнгэрийн доор үйлдэгддэг бүхнийг мэргэн ухаанаар шинжлэн, судлахын тулд би өөрийн оюун ухааныг зориулав. Энэ нь Бурханаас хүний хөвгүүдийг шаналгах гэж өгсөн ёрын бэрх үүрэг байв.
Номлогчийн Үгс 2:10 Миний нүд хүсэмжилж буй бүтдээс би татгалздаггүй. Ямар ч цэнгэл тааламжаас би өөрийгөө татаж байсангүй. Учир нь зүрх минь миний хөдөлмөр бүрд баясах учиртай юм. Энэ л миний бүх л хөдөлмөрийн минь шан харамж ажээ.
Номлогчийн Үгс 2:22,23 Наран доор хичээж чармайсан бүхий л хөдөлмөрөөсөө хүн ер нь юуг нь авах юм бэ? 23 Учир нь хүний бүх л өдрүүд болон хөдөлмөр нь уйтгар зовлонтой, төдийгүй, шөнө ч түүний оюун ухаан нь амардаггүй аж. Энэ нь мөн л хоосон ажээ.
Номлогчийн Үгс 11:10 Иймээс сэтгэлийн зовлон, биеийн шаналлаас зайлж явагтун. Учир нь хүүхэд нас, эрч хүч гэдэг чинь зуурдын юм.
Исаиа 30:29 Найр наадам хийж буй шөнийнх шиг чи дуу хууртай байх болно. ЭЗЭНий уул, Израилийн хад уруу бишгүүрийн аялгуунд алхах шиг зүрх сэтгэл чинь баясна.
Исаиа 57:15 Мөнх амьдрагч Түүний нэр нь Ариун бөгөөд өндөрт өргөмжлөгдсөн Нэгэн үүнийг айлдав. "Би дорд нэгний сүнсийг сэргээж,

гэмшсэн нэгний зүрхийг амьдруулахын тулд гэмшсэн болон даруу сүнстэй хүмүүстэй хамт өндөр, ариун газарт оршдог.

Исаиа 65:14 Үзэгтүн, Миний зарц нар хөөртэй зүрхээр, баяр хөөртэйгөөр хашхирах боловч, та нар хүнд зүрхтэй орилж, цөхөрсөн сүнстэй уйлах болно.

Исаиа 66:13,14 Эх нь хүүгээ тайвшруулдаг шиг Би та нарыг тайвшруулна. Та нар Иерусалимд тайвшрах болно". 14 Үүнийг үзээд та нарын зүрх баясаж, та нарын яс шинэхэн өвс мэт цэцэглэнэ. ЭЗЭНий мутар боолууддаа мэдэгдэнэ. Харин Тэр дайснуудаа зэвүүцнэ.

Иеремиа 15:16 Таны үгс олдсон бөгөөд би тэднийг идсэн билээ. Таны үгс надад баяр хөөр болон зүрх сэтгэлийн минь таашаал болсон билээ. Учир нь түмэн цэргийн Бурхан ЭЗЭН, би Таны нэрээр дуудагдсан билээ.

Иеремиа 24:7 Би тэдэнд Намайг мэдэх зүрхийг өгнө. Учир нь Би бол ЭЗЭН. Тэд Над уруу бүх зүрх сэтгэлээсээ буцаж ирэх тул тэд Миний хүмүүс, Би тэдний Бурхан болно.

Иохан 14:1 Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ.

Иохан 14:27 Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.

Иохан 16:6 Харин Би эдгээрийг та нарт хэлсэн учраас та нарын зүрх сэтгэл уй гашуугаар дүүрэв.

Иохан 16:22 Тиймээс одоо та нар уй гашуу боловч Би та нартай дахин уулзана. Та нарын зүрх баярлана. Та нарын баяр баясгалангхэн ч та нараас булаахгүй.

Үйлс 2:46 Өдөр өдрөөр тэд нэг санаагаар сүмд цутлаж, талхаа айлуудад хуваж, баяр хөөртэйгээр болон чин сэтгэлээсээ хооллоцгоон

Ром 9:2 зүрх сэтгэлд минь маш их уйтгар гуниг, байнгын зовуурь байгааг Ариун Сүнсээр гэрчилж байна.

2 Коринт 2:4 Та нарыг гашуудуулъя гэсэндээ бус, харин надад байгаа та нарын төлөө гэсэн хайрыг та нарт мэдүүлэхийн тулд үлэмж зовлонгоос, бачимдах зүрхнээсээ би нулимс унаган та нарт бичсэн юм.

Ефес 5:19 дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар нэг нэгэнтэйгээ ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохиогтун.

Pastor T. John Franklin
Church of Salvation, Healing, and Deliverance
COS-HAD.org